

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 2023.06.06

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:
1 МАЛ СҮРГИЙГ ТОГТВОРТОЙ ӨСГӨЖ ЧАНАРЖУУЛАХ,
МАЛЧДЫН АМЖИРГААГ ДЭМЖИХ, БЭЛЧЭЭРИЙГ ЗОХИСТОЙ
АШИШЛАХ, УСАН ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, МАЛЫН
ДААТГАЛД ХАМРУУЛАХ УЧИРЖ БОЛШГҮЙ ЭРСДЛЭЭС
ХАМГААЛАХ СУРГАЛТ МЭДЭЭЛЛИЙГ ЦАГ ТУХАЙ БҮР НЬ
ХҮРГҮҮЛЖ АЖИЛЛАХ.

- ▶ **ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Бэлчээрийн даацыг жил бүр цаг уур, байгаль орчны байцаагчтай хамтран тогтоон бэлчээр менежментийн төлөвлөгөөтэй болсон байх, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцсэн байх
- ▶ **ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ:** Малчдаас бэлчээрийн даацтай холбоотой санал хүсэлтүүд их ирж байгааг харгалзан үзэж бэлчээрийн менежментийн төлөвлөгөө гарган ажиллаж сургалт семинарийг зохион байгуулахаар төлөвлөөд байна.
- ▶ **ХҮРСЭН ТҮВШИН:** 80%



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 93 дугаар тогтоолын хавсралт

ӨНДӨРШИЛ СУМЫН БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах албан хаагч
0	1	2	3	4	5	6	7
1	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангаж, тайлагнах	ОНТ	Төлөвлөгөө батлуулж хэрэгжилт гаргасан байх	1	1	1-р улирал	Х.Уугандорж
2	Багийн иргэдээр хэлэлцүүлэн, бэлчээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах журам боловсруулах, батлуулах	ОНТ, малчид	Сумын Засаг дарга болон БИНХ-аас шийдвэрийг гаргаж мөрдүүлэх хэрэгжилтийн хувь	50	80	4 -р улирал	Багийн Засаг дарга нар, ХААТасаг
3	Шинээр өвөлжөө, хаваржааны газрыг малчдад эзэмшүүлэх	ОНТ, малчид	Тухайн жилд өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшсэн малчдын тоо	24	20	Жилдээ	Газрын даамал, ХААТасаг
4	Бэлчээр хашиж хамгаалах болон бэлчээрийг зөв зохистой хамгаалах талаар малчдад сургалт явуулах	ОНТ	Сургалт семинарт оролцсон малчдын тоо	100	100	Жилдээ	Х.Уугандорж

0	1	2	3	4	5	6	7
5	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх	УТ, ОНТ, төсөл хөтөлбөр	Шинээр гаргасан гүн өрмийн худгийн тоо, засварласан худгийн тоо	3	3	2-4-р улирал	Х.Уугандорж
6	Үүлэнд нөлөөлөх замаар хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх	ОНТ	Үүлэнд нөлөөлсөн арга хэмжээний тоо	100	100	2-3-р улирал	Сумын ЗДТГ, Х.Уугандорж
7	Бэлчээрт хөнөөл учруулж буй хортон мэрэгчдийн судалгаа гаргах	ОНТ	Судалгаа хийгдсэн эсэх	100	100	2-4-р улирал	Х.Уугандорж
8	Сумын Засаг даргын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх	УТ, ОНТ	Өвс, тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэлт хувь	80	100	3-4-р улирал	Х.Уугандорж
9	Бэлчээрийн даац, багтаамжийг тодорхойлох	ОНТ	Бэлчээрийн даацыг баг тус бүрээр нарийвчлан гаргасан эсэх	80	100	3-р улиралд	УЦУОШТ

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ: Тэмээ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж тэмээ өсгөсөн айл өрхийг алдаршуулах Тэмээний баяр арга хэмжээг зохион байгуулах

- ▶ **ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ:** Тэмээний баяр тэмээчдийн соёл арга хэмжээг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулж, шилмэл ингэ болон шилмэл буур шалгаруулах уралдаанд 19 малчин өрхийн тэмээчид оролцсон. Мөн тайлаг торомны уралдаан явуулж 60 гаруй тэмээчид оролцсон. Энэхүү байдлаар жил бүр уламжлал болгон зохион байгуулж олон нийтэд тэмээний соёл тэмээний аж ахуйг эрчимтэй бий болгож бүрэлдүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
- ▶ **ХҮРСЭН ТҮВШИН:** 100%



ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ: Улс, аймгийн аварга малчин, Алтан төлийн эзэнд тодорхойлогдох малчдын материалыг журмын дагуу хүргүүлэх

- ▶ **АЖИЛЛАСАН БАЙДАЛ:** Энэ оны эхний хагас жилд Талын нар багийн малчин Ж.Мөнхсайхан, Цог багийн малчин З.Гэрэлчулуун нар Аймгийн аварга малчин болоод байна. Алтан төлийн эзнээр Талын нар багийн малчин Б.Даваасамбуу тодроод байна.
- ▶ **ХҮРСЭН ТҮВШИН:** 100%

ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ: Эдийн засгийн эргэлтэнд орсон
МАЛЫН ТОО

АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН БАЙДАЛ: 65 малчин өрхийн 7859
бог болон бод малыг зах зээлд гарган борлуулаад
байна

ХҮРСЭН ТҮВШИН: 100%

- ▶ **ГУРАВ.** ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ, МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭН АЖИЛЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД
- ▶ **ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Төрийн албан хаагчийн ёс дүрэм журмыг сахин биелүүлж ажиллах
- ▶ **ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ:** Төрийн байгууллагуудын дундах хууль эрх зүйн үйл ажиллагааг зохион байгуулж төрийн байгууллагууд болон ард иргэдэд хууль сурталчилан таниулж байна. Төрийн жинхэнэ албан хаагчын шалшалтад оролцон тэнцэж төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөсөн.
- ▶ **ХҮРСЭН ТҮВШИН:** 100%

- ▶ **ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Хариуцсан ажлын чиглэлээр мэдлэг боловсролоо дээшлүүлэх сургалтанд хамрагдаж бусад сумдтай туршлага солилцон ажиллах
- ▶ **ГҮЙЦЭТГЭСЭН БАЙДАЛ:** Дундговь аймаг болон бусад сумдад болж байгаа туршлага солилцох уулзалт болон сургалт семинарт цаг тухайд нь оролцон ажиллаж байна.
- ▶ **ХҮРСЭН ТҮВШИН:** 100%

- ▶ **ДӨРӨВ:** ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД
- ▶ **ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:** Төрийн албаны тухай хууль, түүнийг дагалдан гарсан хууль тогтоомжид тусгагдсан төрийн албан тушаалд тавигдах шаардлагуудыг хангаж ажиллах
- ▶ **ГҮЙЦЭТГЭСЭН БАЙДАЛ:** Албан тушаалын чиглэлээр болон бусад хууль тогтоомжийг уншин танилцаж Авилгатай тэмцэх хууль, Хоршоо хөгжүүлэх сангийн хууль, Төрийн албаны тухай хуулыг судалж байна
- ▶ **ХҮРСЭН ТҮВШИН:** 100%



АНХААР АЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА